

SMITTSKYDDSBBLAD

Patientinformation

Hepatit C

Översättning till mongoliska

Version 2022-03-15

Гепатит С, өвчтөний мэдээлэл ба дагах дүрэм

Халдвар хамгаалын эмч нарын халдвар хамгааллын тухай хуудас.

Та яагаад энэ мэдээллийг авсан бэ?

Цусны шинжилгээгээр таныг гепатит С-тэй гэдгийг тогтоосон. Энэ хуудсанд гепатит С-ийн талаарх мэдээлэл болон гепатит С-тэй хүнд анхаарах зүйл багтсан болно.

Гепатит С гэж юу вэ?

Гепатит С нь элгэнд халдварладаг вирус боловч өвчний эхэн үед ихэнх хүмүүст өвчний шинж тэмдэг илэрдэггүй. Халдвар нь өөрөө эдгэрч болох боловч ихэнх хүмүүс архаг, насан туршийн халдвартай болдог. Олон жилийн дараа эмчлээгүй гепатит С нь элгийг гэмтээж болно. Өнөөдөр гепатит С-г эмчилдэг энгийн эмчилгээ байгаа тул гепатит С-г эмчлэхэд тусалж чадах эмч, сувилагчтайгаа уулзах нь чухал. Амжилттай эмчилгээ хийснээр таныг халдвараас ангижруулж, элэгний гэмтлийн эрсдлийг бууруулна. Эмнэлгийн үзлэг, эмчилгээ үнэ төлбөргүй.

Гепатит С халдвар эдгэрсэн ч, дахин шинээр халдварлаж болно.

Гепатит С-ийн эсрэг вакцин байхгүй.

Гепатит С яаж халдварлах вэ?

Гепатит С нь халдварт цусаар дамждаг. Мансууруулах бодис хэрэглэдэг хүн тариур, холигч аяга эсвэл өөр хэрэгслээ бусадтай хуваалцвал тэр үед халдварлаж болно. Халдвар зарим ховор тохиолдолд гэмтсэн арьс, салст бүрхэвчид цус хүрсэнээр дамжина. 1992 оноос өмнө Швед улсад цус, цусан бүтээгдэхүүнээр халдвар дамжих эрсдэл байсан. Харин түүнээс хойш бүх цусан бүтээгдэхүүнийг гепатит С-гийн шинжилгээнд хамруулах болсон тул өнөөдөр Шведэд ийм замаар халдвар дамжих эрсдэл маш бага болсон, гэсэн ч дэлхийн өөр өнцөгт ийм тохиолдол гарсан хэвээр.

Үтрээний хавьтлаар халдварлах эрсдэл маш бага. Цус алдалт, салст бүрхэвчийн гэмтэл авах эрсдэлтэй хавьтал буюу жишээ нь шулуун гэдэсний хавьталд орох үед халдварлах эрсдэл өндөр. Түр зуурын бэлгийн хамтрагчтай хавьталд орох эсвэл цус алдах, салст бүрхэвч гэмтэх эрсдэлтэй хавьтлын үед бэлгэвч хэрэглэх нь чухал.

Гепатит С нь тэврэлт, үнсэлт, нулимсаар халдварлахгүй. Цустай холилдоогүй баас, шээс, бөөлжис, нус халдваргүй. Гэмтээгүй арьсанд хүрсэн цус халдваргүй.

Ажил мэргэжил эрхлэх

Гепатит С-ийн халдвар нь ажил мэргэжил эрхлэх, суралцахад ерөнхийдөө ямар нэгэн хязгаарлалт үүсгэхгүй.

Жирэмслэлт

Жирэмсэн эмэгтэй хүүхэддээ халдвар өгөх эрсдэл бага буюу 5 хувиас бага. Тиймээс гепатит С нь жирэмслэлт, хөхүүл үед саад болохгүй. Хэрэв төлөвлөж чадвал жирэмслэхээсээ өмнө өвчнийг эдгээх эмчилгээ хийлгэх нь танд давуу тал болно.

Халдвар мөрдөлт - энэ юу гэсэн үг вэ?

Халдвар авсан байх магадлалтай, цаашлаад халдвар тарааж болзошгүй бусад хүмүүсийг олох нь чухал. Тиймд халдварын мөрдөлт хийгддэг бөгөөд, энэ нь таныг халдварлуулсан байж

болзошгүй эсвэл таны халдварлуулсан байж болзошгүй хүмүүсийг халдварын мөрдөгчид мэдэгдэх ёстой гэсэн үг юм. Таны хувийн мэдээллийг тэдгээр хүмүүст задруулахгүй. Та халдвар мөрдөлтөд оролцох үүрэгтэй.

Бусдыг халдварлуулахгүйн тулд дагаж мөрдөх эрүүл ахуйн зөвлөмж

- Бүх шарханд боолт хийхэд анхаар.
- Хэрэв хэн нэгэн нь танд боолт хийхэд туславал тэр хүн хуванцар бээлий өмсөх хэрэгтэй.
- Цустай материалыг хаяхын өмнө сайтар савла.
- Хувцас тань цуствал машинд угааж болно.
- Жишээлбэл шалан дээрх цусан толбыг нэг удаагийн материалаар арчиж, хая. Дараа нь ус, цэвэрлэх бодисоор сайтар угаа.

Бусдыг халдварлуулахгүйн тулд сахих ёстой дагах дүрэм

- Эмч таныг дуудах үед давтан үзлэгт ирэх шаардлагатай.
- Шүдний болон эмнэлгийн тусламж авах үед та “цусны халдвар”-тай гэдгээ шинжилгээ авах эсвэл мэс засал хийх хүнд хэлэх ёстой.
- Мансууруулах бодис хэрэглэхдээ өөрийн гэсэн тариур, зүүтэй байх ёстой бөгөөд эдгээрийг бусдад бүү хэрэглүүл. Та мөн холигч аяга болон бусад дагалдах хэрэгслийг бусадтай хуваалцаж болохгүй. Тарилгын хэрэгслийг бусдыг халдварлуулах эрсдэлгүй байлгахаар хадгалах ёстой.
- Хэрэв та тариур/зүү/өөр хатгах хэрэгсэл эмнэлэгийн зориулалтаар ашиглаж байгаа бол бусдад ашиглахыг зөвшөөрч болохгүй.
- Хэрэв та шивээс хийх, арьс, чих цоолох, арьсанд цус алдаж болзошгүй бусад эмчилгээ хийлгэвэл "цусны халдвар"-тай гэдгээ хэлэх ёстой.
- Хэрэв хэн нэгний арьсны шархлаа, нүд, хамар, аманд таны цус хүрсэн бол цусыг гепатит С-тэй гэдгийг тэр хүнд мэдэгдэх ёстой ба тэр хэсгийг усаар зайлахыг шамдуулах хэрэгтэй ба түүнд эрүүл мэндийн төв, хамгийн ойр байрлах халдварын эмнэлэг эсвэл 1177 Эмнэлгийн хөтөчтэй холбогдож нэмэлт зөвлөгөө авах нь зүйтэй болохыг мэдэгдэх.
- Сахлын хутга, шүдний сойз зэргийг хэн нэгэнтэй нь бүү хуваалц.
- Та цус өгөх эсвэл эр бэлгийн эс / өндөг хандивлаж болохгүй. Зарим тохиолдолд шилжүүлэн суулгах зориулалтаар эрхтэн, эд эсийг хандивлах боломжтой.
- Бэлгийн хавьталд орох үед цус алдах ба/эсвэл салст бүрхэвч гэмтэх эрсдэлтэй байвал гепатит С-тэй гэдгээ бэлгийн хамтрагчдаа мэдэгд. Энэ нь та бэлгэвч хэрэглэхээр төлөвлөсөн тохиолдол ч хамаатай болно.
- Бэлэг эрхтэнг үтрээ, шулуун гэдэс, амны хөндийд оруулах үед цус алдах ба/эсвэл салст бүрхэвч гэмтэх эрсдэлтэй байвал хавьтлын туршид бэлгэвч хэрэглэ.

Гепатит С нь Халдвар хамгааллын хуульд зааснаар нийтэд аюултай өвчин юм. Тиймээс та эмчийн зааж өгсөн дагах дүрмийг сахих ёстой. Та аймгийнхаа халдвар хамгааллын эмчээс өөрт өгсөн дагах дүрмийг дахин авч хэлэлцэхийг хүсч болно. Үүнийг шийдвэрлэж дуустал та өөрт өгсөн дүрмийг даган мөрдөх ёстой.

Та нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?

Гепатит С-ийн талаарх нэмэлт мэдээлэл дараах хаяг дээр бий:

www.1177.se

www.umo.se

www.folkhalsomyndigheten.se